

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН**

**УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: ЗАА-2022/16-12/ШТА-ГА

Улиастай сум 2022 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 7046-3783, Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Заяа
Утас: 92038288, Цахим хаяг: zayag@audit.gov.mn
Аудитор Б.Мөнхнасан
Утас: 90066888, Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА	4-9
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ӨМНӨХ ОНООС БУУРСАН БАЙНА.....	9-17
ДҮГНЭЛТ	18-19
ЗӨВЛӨМЖ:	20
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	21
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР.....	22
АЛДАА ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ.....	23
АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	24

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний Аудитын гараас гүйцэтгэх сэдвийг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байна уу?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байна уу?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн ГХБХБГ, аймгийн Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гүйцэтгэгч компаниуд, ашиглагч байгууллагуудын 2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий Аудиторов 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга болон судалгаа авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Б.Дагвасүрэн нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, аудитор Б.Мөнхнасан нар 2022 оны 03 дугаар сарын 25-ээс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 30-ний хооронд гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхдөө орон нутгийн салбарын бодлого, аймгийн Засаг даргын саналд үндэслээгүй байна.

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөрт тусгагдаагүй байна.

таван жилийн үндсэн чиглэлтэй нийцээгүй байна.

Хүснэгт № 1 Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй нийцсэн эсэх

Төсөл арга хэмжээний нэр	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр
Алдархаан, Тосонцэнгэл, Шилүүстэй сумдын сургуулийн барилгын их засвар	Нийцсэн	Нийцсэн	Нийцсэн	Нийцээгүй
Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах	Нийцсэн	Нийцсэн	Нийцсэн	Нийцээгүй
Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засвар	Нийцээгүй	Нийцээгүй	Нийцсэн	Нийцээгүй

А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн салбарын бодлого, аймгийн Засаг даргын саналд үндэслээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын бодлогын хэлтсээр нэгтгэгдэлгүй жагсаалтад батлагдаж байгаа зөрчил аудитаар ажиглагдаж байна. Тухайлбал: Алдархаан сумын Засаг дарга, Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн дарга, Тосонцэнгэл, Шилүүстэй сумдын сургуулийн удирдлагууд барилгын их засварын ажлуудыг УИХ-н гишүүд, холбогдох яамд уламжлан шийдвэрлүүлснийг дурьдаж болно.

Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлыг төлөвлөхдөө аймгийн Засаг даргаас санал авалгүйгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2021 оны А/104 дугаар тушаалаар батлагдсан аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын хуваарьт тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 5 их засварын төсөл арга хэмжээ нь Аймгийн Засаг, ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэсийн саналыг үндэслээгүй байна.

А.1.3. Сангийн яам аймгийн Засаг даргын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар 7 яам руу 65 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр санал хүргүүлснээс он дамжин хэрэгжиж байгаа нэг төсөл арга хэмжээ жагсаалтад батлагдсан байна.

А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна.

А.2.1. Он дамжин хэрэгжсэн 13 барилгын ажлын зураг төсөл зохиох ажлын даалгаврын иж бүрэн боловсруулагдсан байдалд зөрчил илрээгүй.

Аудитын илрүүлэлт:

Ургамал, Шилүүстэй сумдын ЗДТГ, Баянхайрхан сумын цэцэрлэгийн барилгуудын дулаан хангамжийн техникийн нөхцөлийг аваагүй байна. Энэ нь анх зургийн даалгаврыг боловсруулах үед тус сумд нэгдсэн халаалтын шугамд холбогдоогүй байсантай холбоотой бөгөөд уурын зуухны барилга барихаар төлөвлөгдсөн байна. Аудитын явцад Ургамал сумын ЗДТГ-ын барилгын зураг төсөвт зохиогчийн зөвшөөрлөөр өөрчлөлт оруулсан бол Шилүүстэй сумдын ЗДТГ, Баянхайрхан сумын цэцэрлэгийн барилгын зурагт өөрчлөлт оруулаагүй, барилгын 70-80 гүйцэтгэсэн, гүйцэтгэлдээ уурын зуухны барилгыг бариагүй мөртлөө барьсан мэтээр тайлагнасан зөрчил илэрлээ.

А.2.2. Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд боловсруулж, баталгаажуулжээ.

Тайлант онд шинээр хэрэгжсэн 5 их засварын ажил, он дамжин хэрэгжсэн 16 барилгын ажлын зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 10 хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан байна.

А.2.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардал нь зураг төслийн ажлын жишиг үнээс 2-10 хувиар бага байна.

Эрх шилжин хэрэгжсэн 21 төсөл арга хэмжээний зураг төслийн зардлын гүйцэтгэлийг Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 182 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын дүрэм батлах тухай”, Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн ажлын жишиг үнэ” зэрэгтэй харьцуулахад 2-10 хувиар бага байна. Энэ нь барилгын ажлын зургийг боловсруулахдаа нэг маягийн, холболтын зургийг ашигладаг, зураг төсвийн зардлыг гэрээгээр тохирон зээлээр хийлгэсний дараа Монгол Улсын төсвийн хуулинд тусгагдан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дараа гүйцэтгэлээс суутган төлдөг зэрэгтэй холбоотой байна. Энэ нь аймаг, сумын удирдлагаас барилга байгууламжийн зураг төсөв хийлгэж, улсын төсөвт тусгуулахаар хүргүүлсэн санал тэр бүр хэрэгждэггүйгээс шалтгаалж байна.

Аудитын илрүүлэлт:

2019 онд Тэлмэн сумын Засаг дарга аймгийн Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэсийн зөвшөөрөлгүйгээр Тэлмэн сумын сургуулийн барилгын зураг төслийг хийлгэхээр “Кинг сий инженер энд констракшин консалтинг групп” ХХК-тай 40.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, 2020 оны 2 сард тус компани нь сургуулийн барилгын зураг төсөлд магадлал хийлгэсний дараа 18.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гэвч Тэлмэн сумын Засаг дарга аймгийн Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэст зураг төслийн талаарх мэдээллийг тухайн үедээ хүргүүлээгүйгээс шалтгаалан 2020 оны 03 дугаар сард Тэлмэн сумын сургууль, спорт заалны барилгын гүйцэтгэгчийг түлхүүр гардуулах нөхцөлөөр сонгон шалгаруулах хүсэлтийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт гаргаснаар Тэлмэн сумын ОНХС-д 18.0 сая төгрөгийн хохирол учирсан байна. Аудитаар Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтод тусгагдсан 2.0 сая төгрөгийн инженер геологийн зардлыг Тэлмэн сумын ОНХС-д төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

А.2.4. Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу магадлалаар баталгаажуулсан, их засварын ажлын зураг төслийг хянуулах ажил шаардлагын түвшинд хүрээгүй байна.

Он дамжин хэрэгжсэн 16 барилгын ажлын, тайлант онд шинээр хэрэгжсэн нэг их засварын ажлын зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр магадлан баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Шилүүстэй, Алдархаан сумдын сургуулийн барилгуудын их засварын, Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлын зургуудыг аймгийн ерөнхий архитектороор, Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлын, Алдархаан сумын сургуулийн их засварын төсвийг тэргүүлэх төсөвчнөөр тус тус хянуулаагүй байна.

А.2.5 Барилга байгууламжийн ажлын зургийг эх загвар, нэг маягийн болон холболтын зургийн дагуу боловсруулан мэргэжлийн экспертүүдээр хянуулсан байна.

Он дамжин хэрэгжсэн 16 барилгын ажлын зураг, магадлалын нэгтгэсэн дүгнэлттэй танилцахад 9 барилгын ажлын зургийг эх загвар зургийн дагуу, 2 барилгын ажлын зургийг нэг маягийн зургийн дагуу, 5 барилгын ажлын зургийг холболтын зургийн дагуу боловсруулан мэргэжлийн экспертүүдээр хянуулсан байна.

А.3.Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулаагүй байна.

А.3.1. Хэрэгцээ шаардлагагүй 2 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөнийг орон нутгаас хүсэлт гарган өөрчлүүлсэн байна.

Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засвар, Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажил нь орон нутагт хэрэгцээ шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

Боловсрол шинжлэх ухааны яамны 2021 оны А/13 тоот тушаалаар Алдархаан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын болон Шилүүстэй сумын сургуулийн дотуур байрны их засварын төсөвт өртгийг тус бүр 80.0 сая төгрөгөөр баталсан байсныг Алдархаан сумын Засаг дарга, Шилүүстэй сумын сургуулийн захирлын албан хүсэлтээр Алдархаан сумын сургуулийн дотуур байрны засвар, Шилүүстэй сумын сургуулийн хичээлийн байрны засвар болгож өөрчилсөн байна. Учир нь 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алдархаан сумын цэцэрлэгийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулсан, аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр Шилүүстэй сумын сургуулийн дотуур байрны их засварыг хийсэн байжээ.

Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн их засварын ажлын санхүүжилт болох 110.0 сая төгрөгөөр сургуулийн гадна талын явган замыг хийсэн нь Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэсийн боловсруулсан саналд үндэслэгдээгүй, орон нутагт нэн тэргүүний эрэлт хэрэгцээтэй ажил биш байсан байна

гэж үзлээ.

А.3.2. Шинээр хэрэгжүүлэх 4 их засварын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн гадна тохижилтийн ажлын зураг төсөв нь 2020 онд хийгдэн, магадлалаар баталгаажуулагдсан бол бусад 4 их засварын ажлын зураг төсвийг 2021 онд хийлгэн, холбогдох мэргэжилтнээр хянуулаагүй байна.

А.3.3. Шинээр эрх шилжин хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулжээ.

А.3.4. Шинээр эрх шилжин хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын шинж чанартай байна.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ӨМНӨХ ОНООС БУУРСАН БАЙНА.

Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа захиалагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-д заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Б.1.1. Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засварын ажлаас бусад 4 төсөл, арга хэмжээний эрхийг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайдын 2021 оны А/09 тоот тушаалаар шилжүүлснийг 2021 оны 05 сарын 20-нд аймгийн Орон нутгийн өмчийн газар хүлээн авсан бөгөөд 2021 оны 07 дугаар сарын 02-нд нэр, байршил зөрүүтэй шалтгаанаар буцаагдан, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр эргэн эрх нь шилжин ирсэн. Тухайн тендерийн нэрний зөрүүтэй байдал арилаагүй бөгөөд аймгийн Орон нутгийн өмчийн газар худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулж 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулах эрхийг олгосон нь төсөл хэрэгжих хугацаанд сөргөөр нөлөөлсөн байна.

Б.1.2. Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засварын ажлаас бусад 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжийг хангах хугацаанд зохион байгуулжээ.

Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засварын нэр, байршил зөрүүтэй шалтгаанаар эрх нь хугацаа оройтон шилжиж ирснээс шалтгаалан худалдан авах ажиллагааг 2021 оны 4 дүгээр улиралд зохион байгуулснаар ажлын гүйцэтгэл бүрэн хангагдаагүй.

Б.1.3. Зураг төсөлгүй 3 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг ажлын тоо хэмжээг үндэслэн боловсруулж, батлуулж, хэрэгжүүлсэн байна.

Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн гадна талбайн тохижилт хийх ажлын тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийн дагуу, 4 их засварын ажлын тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Харьцуулалтын аргаар ажил худалдан авахад ашиглах тендерийн жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулан батлуулж хэрэгжүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

Алдархаан, Шилүүстэй сумдын сургуулийн барилгын их засварын ажлын болон Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлын зураг төсвийг захиалагч хуулийн хугацаанд бэлтгээгүйгээс шалтгаалан зөвхөн ажлын тоо хэмжээгээр тендерийг зарласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар 48.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулжээ.

Шинээр эрх шилжин хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээний Худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулжээ. Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан "Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн гадна талбайн тохижилт"-ын ажлын тендерийн урилгыг хуулийн дагуу "Зууны мэдээ" өдөр тутмын сонины 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн №66 (6543) дугаарт нийтлүүлсэн байна.

Б.1.5. Аймгийн Засаг дарга худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнаж, шилэн дансанд тавьж, нийтэд мэдээлсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг цахим системээр хөтлөн, хуулийн хугацаанд Төрийн худалдан авах ажиллагааны газар болон Сангийн яаманд хүргүүлсэн байна. 2021 онд Худалдан авах ажиллагааны үр дүнг тухай бүрд цахим системд бүртгэн, худалдан авах ажиллагааны тайланг шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд багтаан бүртгэжээ.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг зохион байгуулаагүй байна.

Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээг батлагдсан зураг, төсвөөр захиалагчтай байгуулсан гэрээний дагуу үр дүнтэй гүйцэтгэжээ.

Тайлант онд Түдэвтэй, Ургамал сумдын ЗДТГ-ын барилга барих, Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн гадна талбайн тохижилт хийх ажлын гүйцэтгэгч нар батлагдсан зураг төсөл, төсвөөр захиалагчтай байгуулсан гэрээний дагуу төсөл арга хэмжээг үр дүнтэй гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэж өгсөн байна.

Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Шилүүстэй сумын ЗДТГ-ын барилга, Жавхлант цогцолбор сургуулийн барилга, Асгат сумын 75 хүүхдийн дотуур байрны барилга, Тэлмэн, Сонгино, Идэр сумдын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилга, Тосонцэнгэл сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Цэцэн-Уул, Баянхайрхан сумдын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Улиастай сумын гудамж төсөл зэрэг 10 төсөл арга хэмжээ гэрээт хугацаандаа ашиглалтад орж чадалгүй 2022 онд хийж дуусгахаар гэрээгээ сунгажээ.

Нисэх буудлын авто замын уулзвараас Алдархаан сумын төв хүртэлх 6.7 км хатуу хучилттай авто зам барих ажлын гүйцэтгэгч асфальт хүлээгдсэн шалтгаанаар гэрээт хугацаандаа ашиглалтад орж чадалгүй 2022 онд хийж дуусгахаар гэрээгээ сунгажээ.

Аудитын илрүүлэлт:

-Шилүүстэй, Алдархаан сумдын сургуулийн барилгуудын их засварын, Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлын зураг, төсвийг холбогдох мэргэжилтнүүдээр хянуулаагүй байхад аймгийн ГХБХБГ ашиглалтад хүлээн авсан.

- Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засварын ажлын гэрээг 2021 оны 10 дугаар сарын 28-нд байгуулан, хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор ажлын тоо хэмжээнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдээгүй;

-Нөмрөг сумын соёлын төвийн барилгын гүйцэтгэгч 1-р давхрын цутгалтын хэв хашмал муу хийнээс багана дам нуруу цүлхийж сэнсэрсэн, 2-р давхарын багана хэв хашмал алдаатай хийгдсэн тул мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулсан, 2021 оны 10 дугаар сарын 01-нд дуусгахаар гэрээтэй боловч гэрээгээ сунгаагүй;

-Түдэвтэй соёлын төвийн барилга 2021 оны 10 дугаар сарын 01-нд дуусгахаар гэрээтэй боловч гэрээгээ сунгаагүй;

- Хөгжимт жүжгийн театрын барилга 2021 оны 12 дугаар сарын 25-нд дуусгахаар гэрээтэй боловч гэрээгээ сунгаагүй;

Б.2.2. Аймгийн ГХБХБГ-аас барилгын үе шат бүрд очин захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, барилгын гүйцэтгэлд тавих зохиогчийн хяналтыг чанаржуулах шаардлагатай байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/09 дугаар тушаалаар Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засварын ажилд хяналт тавих эрхийг аймгийн НДХ-ийн даргад шилжүүлсэн боловч аймгийн ГХБХБГ-тай гэрээ байгуулаагүйгээс шалтгаалан их засварын ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт хэрэгжээгүй байна.

Аймгийн ГХБХБГ-аас Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлаас бусад төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг 1-4 удаа газар дээр нь очин хэрэгжүүлсэн, барилгыг ашиглалтад хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулж хэвшсэн байна.

Аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүд барилгын үе шат бүрт хяналт тавьж хэвшээгүй байна. Үүнд гүйцэтгэгч зохиогчийн хяналтаар илрүүлсэн зөрчлийг хэрхэн арилгасныг, өмнөх хяналтаар болон барилга ашиглалтад хүлээн авах комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт зэргийг хянаж хэвшээгүй.

Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлаас бусад төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд зураг төслийн байгууллагаас зохиогчийн хяналтыг 3 удаа газар дээр нь очин хэрэгжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитын үеэр зохиогчийн хяналт нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл, хяналтын тайлангаар нотлогдоогүй, интернетээр хянасан мөртлөө илүү нэхэмжилсэн

зөрчлүүдийг илрүүлэн 16.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж бэлтгэгдээгүй байна.

Б.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон нэг барилга, хэрэгжээгүй нэг ТЭЗҮ, 7 зураг төсөл байна.

Их-Уул сумын доторх 3 км хатуу хучилттай авто зам барих ажил нь 1,998.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 2019 оны 07 дугаар сарын 26-нд баригдаж эхлэн 2021 оны 08 дугаар сарын 01-нд дуусгахаар гэрээ байгуулсан, 2019-2020 онд 1783.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч замын ажлыг 90 хувьтай гүйцэтгэсэн байна. 2020 онд уг замын ажлын зураг төсөв өөрчлөгдсөн шалтгаанаар ажил бүрэн хийгдэж дуусаагүй байснаас шалтгаалан Сангийн яам үлдэгдэл 214.6 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн бөгөөд Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулинд тусгагдалгүй орхигджээ.

2012-2020 оны хугацаанд 139.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээний зураг төсөл, Отгонтэнгэр аялал жуучлалын цогцолбор байгуулах төслийн ТЭЗҮ-ийг Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс боловсруулсан боловч одоогоор хэрэгжээгүй байна.

Б.2.5. Төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх жилүүдэд төлөвлөсөн ТЭЗҮ-ийг 2021-2022 онд холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашиглаагүй байна.

Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

Б.3.1. Захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй, барилга байгууламжийн үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлэлгүй, гүйцэтгэлийг баталгаажуулж байна.

Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс нь тайлант онд барилга байгууламжийн санхүүжилтийг олгохдоо 298.2 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутган За.техник хяналт дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Засаг дарга нь барилга байгууламжийн хяналт хийлгэхээр аймгийн ГХБХБГ руу 31.6 сая төгрөгийг, Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө

оруулалтын хэлтэс рүү 4.0 сая төгрөгийг шилжүүлэн, “Идэр Тэс” ХХК-ийн өмнөх ажлын санхүүжилтийн өрөнд 45.0 сая төгрөгийг шилжүүлэн, 20.0 сая төгрөгийг Аймгийн ЗДТГ, ГХБХБГ-ын автомашинуудын засварт зориулалт бусаар зарцуулсан.

- Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэст захиалагчийн хяналтын зардлыг харьцангуй бага хуваарилсан, мэргэжилтнүүдийн тоо цөөн, ачаалал ихтэй байдлаас шалтгаалан барилгын бодит гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах ажил шаардлагын түвшинд хүрээгүй.
- Захиалагч зохиогчийн хяналт хийх гэрээнд хяналтын тоог тусгадаггүй, барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд зохиогч үүрэг өгсөн эсэхийг хянадаггүй, зохиогчтой хяналтын зардлын гүйцэтгэлийн нэгдсэн акт үйлдэж байгаа ч зохиогчийн хяналтын тайлангаар баримтжуулж хэвшээгүй, зураг төсөвт өөрчлөлт оруулсан зохиогчийн зөвшөөрлийг тэр бүр шаардаж авдаггүй дутагдал нийтлэг байна.

Эндээс харахад аймгийн Засаг дарга захиалагчийн хяналтын зардлыг аймгийн ГХБХБГ руу хуваарилахдаа бодит гүйцэтгэлд үндэслээгүй, нийт төвлөрүүлсэн хяналтын зардлын 10 орчим хувийг олгож байгаагаас барилга байгууламжийн үе шат бүрд очин, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Нөгөө талаас аймгийн ГХБХБГ-т барилгын чиглэлийн 4 мэргэжилтэн ажилладаг, авто замын чиглэлийн мэргэжилтэн ажилладаггүй, зураг төсөв болон хяналт хариуцсан мэргэжилтнүүдийн мэргэшсэн байдал хангалтгүй байгаа нь захиалагчийн хяналтын үр дүнд сөргөөр нөлөөлжээ.

Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм” -ийн 1 дүгээр хавсралтаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд оролцдоггүй, аймгийн ГХБХБГ-ийн мэргэжилтнүүдийн тоо цөөн байдлаас шалтгаалан барилга байгууламжийн үе шатанд хяналт тавьсан мэргэжилтэн ашиглалтад хүлээж авах комисст оролцож байгаа нь барилга барих явцад илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулаагүй байхад ашиглалтад авах эрсдлийг бий болгож байна.

Б.3.2. Төсөл, арга хэмжээний 83 хувийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгожээ.

Тайлант онд санхүүжилтийн эрх шилжиж ирсэн 18 төсөл арга хэмжээнээс 15 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Идэр сумдын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилгын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 292.0 сая төгрөгөөр илүү олгосон. Санхүүжилтийн гүйцэтгэл бодит гүйцэтгэлээс 18 хувиар илүү байгаа шалтгааныг гүйцэтгэгчээс тодруулахад материалаа өвлийн улиралд татан авсан гэсэн тайлбарыг өглөө.

-Баянхайрхан сумын цэцэрлэгийн барилгын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 113.9 сая төгрөгөөр илүү олгосон. Гүйцэтгэгч уурын зуухны барилга бариагүй, уурын зуух суурилуулаагүй, гадна тохижилт, явган замын ажлыг хийгээгүй байж гүйцэтгэлийг хийсэн мэтээр гаргасныг захиалагч хяналгүйгээр баталгаажуулсан байна.

-Шилүүстэй сумын ЗДТГ-ын барилгын гүйцэтгэгч уурын зуухны барилга бариагүй, уурын зуух суурилуулаагүй, гадна тохижилтыг хийгээгүй мөртлөө 122.3 сая төгрөгийн гүйцэтгэлийг хийсэн мэтээр гаргасныг захиалагч хяналгүйгээр баталгаажуулсан, уг ажлын санхүүжилтийг хугацаа оройтож орж ирсэн шалтгаанаар олгоогүй байна.

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Аймгийн ЗДТГ-ын дотоод хяналт, дотоод аудитын хяналт үр нөлөө муутай байна.

Аймгийн ЗДТГ-ын дотоод хяналт, дотоод аудитын хэлтсээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүнд хяналт үнэлгээ хийх ажлын үр нөлөө хангалтгүй байна. Тус хэлтэс нь аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэсээс авсан мэдээлэлд үндэслэн хэрэгжилтийн хувь тавих замаар хяналт үнэлгээг хийж байгаагаас үндэслэн дээрх дүгнэлтийг гаргаж байна.

Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй байна.

Б.4.1. Тайлант онд аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг зорилтын дагуу зарцуулжээ.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10 төсөл арга хэмжээний 5,716.4 сая төгрөгийн санхүүжилт 2021 оны 12 дугаар сарын 15-наас хойш орж ирснийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ. Барьцаа хөрөнгийн данснаас 2020 онд ашиглалтад орсон Тосонцэнгэл сумын 2 дугаар сургуулийн барилгын үлдэгдэл санхүүжилт 224.5 сая төгрөгийг барьцаалсан байсныг чөлөөлсөн байна.

Б.4.2. Өмнөх онуудад аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Өмнөх оны барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 441.8 сая төгрөг байсан бөгөөд 2021 онд өмнөх оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл санхүүжилт 356.1 сая төгрөгийг барьцаалсан байсныг чөлөөлсөн байна.

Хүснэгт №2. Барьцаа хөрөнгийн дансны зарцуулалт

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Үлдэгдэл санхүүжилт / сая, төгрөг/
1	Товцог багийн бохир усны шугамын ажил	Зуурмаг ХХК	201.8
2	Тэс сумын спорт заалны барилгын ажил	Бүгд гэгээн өгөөмөр	100.0
3	Аудитын актын төлбөр	Магадлашгүй ажлын акт	5.8
4	45 км агаарын шугам чанарын баталгаа	"Монхас" ХХК	48.5
	Нийт дүн		356.8

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт тэр бүр хангагдаагүй байна.

Б.5.1. 2021 онд байнгын ашиглалтад орсон 4 барилга байгууламжийг ашиглагч бүртгэлд тусгаагүй боловч зориулалтын дагуу ашиглаж байна.

Тайлант онд ашиглалтад орсон 6 төсөл арга хэмжээнээс ашиглагч Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн гадна талбайн тохижилт, Шилүүстэй сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлуудыг бүртгэлд тусган, зориулалтын дагуу ашиглаж байна.

Аудитын илрүүлэлт:

-Алдархаан сумын сургуулийн дотуур байрны их засвар, Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажил, Тосонцэнгэл сумын нийгмийн даатгалын тасгийн барилгын их засвар, Түдэвтэй сумын ЗДТГ-ын барилга зэрэг 1,399.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг ашиглагч бүртгэлд тусгаагүй байна.

Б.5.2. Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд болон он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдээгүй байна.

Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр ажил зохион байгуулдаггүй, хэрэгжилт 30.0% -тай байгаа нь зөрчил, дутагдал арилахгүй байхын нэг шалтгаан болж байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө, гүйцэтгэлийн аудитаар 12 заалт бүхий зөвлөмж хүргүүлснээс 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2021 оны 9 дүгээр сард УАГ-ын Гуравдугаар газраас хийсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Завхан аймагт хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт” сэдэвт эрсдлийн аудитаар аймгийн Засаг даргад 32 зөвлөмж өгчээ. Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад хариуцлага тооцохтой холбоотой 5 зөвлөмжийг хэрэгжүүлсэн, Рашаант багаас Хожуулын голын рашаан сувилал хүртэлх 35 км 10 квт-ын ЦДАШ барих ажлын гүйцэтгэлийн хувийг газар дээр нь очиж шалгасан, харин үлдсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, аймгийн ГХБХБГ-аас гүйцэтгэгч компаниуд руу 2021 оны 12 дугаар сарын 30-ны 623 тоот албан бичгээр зөрчил гаргасан гүйцэтгэгч нар руу шаардлага хүргүүлсэн бөгөөд одоогоор биелэлтээ аваагүй байна.

Завхан аймаг дахь төрийн аудитын газраас 1 албан шаардлага хүргүүлснийг аймгийн Засаг даргаас 2022 оны 05 дугаар сарын 01 хүртэл сунгах хүсэлт ирүүлсэн байна.

Б.5.4. Улсын төсвийн санхүүжилтээр эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулаагүй байна.

Б.5.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөгөөр дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдэж байна.

Аймгийн дэд бүтцийн салбарын хүчин чадлыг нэмэгдүүлсэн 9,792.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улиастай сумын гудамж төсөл, 5,314.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Доной нисэх буудлын авто замын уулзвараас Алдархаан сумын төв хүртэлх 6.7 км хатуу хучилттай авто зам барих ажлуудын гүйцэтгэлд хяналт тавих эрхийг аймагт шилжүүлсэн байна. Энэ 2 төсөл арга хэмжээ нь 2022 онд ашиглалтад орохоор гэрээний хугацаагаа сунгуулжээ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхдөө орон нутгийн салбарын бодлого, аймгийн Засаг даргын саналд үндэслээгүй байна.
2. Шилүүстэй сумдын ЗДТГ, Баянхайрхан сумын цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгч ажлын зурагт өөрчлөлт оруулалгүйгээр барилгын ажлын 70-80 хувийг гүйцэтгэсэн, гүйцэтгэлдээ уурын зуухны барилгыг бариагүй мөртлөө барьсан мэтээр тайлагнасныг захиалагч хянаагүй зөрчил илэрлээ.
3. Их засварын ажлын зураг, төсвийг холбогдох мэргэжилтнээр хянуулахгүйгээр комисс ашиглалтад хүлээн авдаг зөрчил нийтлэг байна.
4. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Шилүүстэй сумын ЗДТГ-ын барилга, Жавхлант цогцолбор сургуулийн барилга, Асгат сумын 75 хүүхдийн дотуур байрны барилга, Тэлмэн, Сонгино, Идэр сумдын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилга, Тосонцэнгэл сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Цэцэн-Уул, Баянхайрхан сумдын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Улиастай сумын гудамж төсөл зэрэг 10 төсөл арга хэмжээ гэрээт хугацаандаа ашиглалтад орж чадалгүй 2022 онд хийж дуусгахаар гэрээгээ сунгажээ.
5. Нисэх буудлын авто замын уулзвараас Алдархаан сумын төв хүртэлх 6.7 км хатуу хучилттай авто зам барих ажлын гүйцэтгэгч асфальт хүлээгдсэн шалтгаанаар гэрээт хугацаандаа ашиглалтад орж чадалгүй 2022 онд хийж дуусгахаар гэрээгээ сунгасан байна.
6. Аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүд барилгын үе шат бүрт хяналт тавьж хэвшээгүй байна. Үүнд гүйцэтгэгч зохиогчийн хяналтаар илрүүлсэн зөрчлийг хэрхэн арилгасныг, өмнөх хяналтаар болон барилга ашиглалтад хүлээн авах комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт зэргийг хянаж хэвшээгүй
7. Аймгийн Засаг дарга захиалагчийн хяналтын зардлыг аймгийн ГХБХБГ руу хуваарилахдаа бодит гүйцэтгэлд үндэслээгүй, нийт төвлөрүүлсэн хяналтын зардлын 10 орчим хувийг олгож байгаагаас барилга байгууламжийн үе шат бүрд очиж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
8. Аймгийн Засаг дарга нь 20.0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын автомашинуудын засварт зориулалт бусаар зарцуулжээ.
9. Захиалагч зохиогчийн хяналт хийх гэрээнд хяналтын тоог тусгадаггүй, барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд зохиогч үүрэг өгсөн эсэхийг хянадаггүй, зохиогчтой хяналтын зардлын гүйцэтгэлийн нэгдсэн акт үйлдэж байгаа ч зохиогчийн хяналтын тайлангаар баримтжуулж хэвшээгүй, зураг төсөвт өөрчлөлт оруулсан зохиогчийн зөвшөөрлийг тэр бүр шаардаж авдаггүй дутагдал нийтлэг байна.
10. Өмнөх онд ҮАГ-аас хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг байна.

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд

1. Сумын засаг дарга, байгууллагын удирдлагууд аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ-ын бодлогын хэлтэст улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналаа уламжлуулан нэгдсэн бодлогод уялдуулах үүргийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэн, биелэлтийг тооцох;
2. Шилүүстэй сумдын ЗДТГ, Баянхайрхан сумын цэцэрлэгийн барилгын зурагт өөрчлөлт оруулах, төсвийн зөрүү тооцох, гүйцэтгэлийг үнэн зөв гаргуулах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах үүргийг аймгийн ГХБХБГ-т өгч хэрэгжүүлэх;
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар 48.3-д заасан үүргийг хэрэгжүүлэн жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээний зураг төсвийг бэлтгэн аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх, төсөл арга хэмжээний зураг төсөв, инженер геологийн зардлыг орон нутгийн төсвөөс урьдчилан гаргасан тохиолдолд тендер шалгаруулалтын өгөгдлийн мэдээлэлд тусгаж хэвших;
4. Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, ГХБХБГ-т хуваарилах хяналтын зардлын хэмжээг нэмэгдүүлэн, барилгын үе шат бүрт тавих хяналтын чанарыг сайжруулах үүргийг өгч хэрэгжүүлэх;
5. Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох, зохиогчтой байгуулсан гэрээнд хяналтын тоог тусган, гэрээг дүгнэх, ашиглалтад орсон барилга байгууламжтай холбоотой баримтын хувийг ашиглагчид хүлээлгэн өгч бүртгэлд тусгуулж хэвших;
6. Бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгодог, барилгыг ашиглалтад хүлээж авахдаа зураг төсөвтэй тулгадаггүй, гүйцэтгэл дутуу байхад үүрэг даалгавраар ашиглалтад хүлээж авдаг, биелэлтийг нь эргэж хянадаггүй зэрэг зөрчлүүдийг таслан зогсоох үүргийг үүргийг аймгийн ГХБХБГ-т өгч, хэрэгжүүлэх;

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын нэр: Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын код: 3AAG-2022/16-12/ШТА-ГА

Байгууллагын нэр: Зөвхөн аймаг дахь ТАГ

№	Аудитын чиглэл/ асуулт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагддаг байгууллагын санал, тайлбар	2022.04.30
						Гаргасан шийдвэр
4	A.2.3. Барилга байгууламжийн зурга төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишэг үнийг үндэслэсэн үү?	2019 онд Талман сумын Засаг дарга аймгийн Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэсийн зөвшөөрөлгүйгээр Талман сумын сургуулийн барилгын зурга төсвийг хийлгэхээр "Юнг сий инженер энд консалтинг групп" ХХК-тай 40.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, 2020 оны 2 сард тус компани нь сургуулийн барилгын зурга төсөлд магадлал хийлгэсний дараа 18.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гэвч Талман сумын Засаг дарга аймгийн Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэст зурга төслийн талаарх мэдээллийг тухайн үеэс хуруулзгүйгээс шалтгаалан 2020 оны 03 дугаар сард Талман сумын сургууль, спорт заалны барилгын гүйцэтгэчийг түлхүүр гардуулах нөхцөлөөр сонгон шалгаруулах хүсэлтийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт гаргаснаар Талман сумын ОНХС-д 18.0 сая төгрөгийн хохирол учирсан байна.	16.0	Зөвлөмж өгсөн	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж өгсөн
	A.2.3. Барилга байгууламжийн зурга төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишэг үнийг үндэслэсэн үү?	Аудитаар Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтод тусгагдсан 2.0 сая төгрөгийн инженер геологийн зардлыг Тангэрийн тэмдэг ХХК төсөвтөө тусгаагүй тул Талман сумын ОНХС-д төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.	2.0	Төлбөрийн акт	Хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт
	A.2.4. Барилга байгууламжийн зурга төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төслийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлаар баталгаажуулсан үү?	Шилүүстэй, Алдархаан сумдын сургуулийн барилгуудын их засварын, Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлын зургуудыг аймгийн өрөөний архитектороор, Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт түр буудаллах цэгийг тохижуулах ажлын, Алдархаан сумын сургуулийн их засварын төслийг тэргүүлэх төсөөнөөр тус тус хянуулаагүй байна.	250.5	Зөвлөмж өгсөн	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж өгсөн
	B.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зурга төсөл, төсвөөр захиалгатай байгуулсан гэрээний дагуу үр дүнтэй гүйцэтгэсэн үү?	Тосонцангал сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгын их засварын ажлын гэрээг 2021 оны 10 дугаар сарын 28-нд байгуулан, хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор ажлын тоо хэмжээнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдээгүй.	30.0	Зөвлөмж өгсөн	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж өгсөн
4	B.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зурга төсөл, төсвөөр захиалгатай байгуулсан гэрээний дагуу үр дүнтэй гүйцэтгэсэн үү?	Нөмрөг сумын сойлын төвийн барилгын гүйцэтгэгч 1-р давхарын цутгалтын хэв хашмал муу хийнээс багана дам нуруу цутгийг сэжиссэн, 2-р давхарын багана хэв хашмал алдаатай хийгдсэн тул маргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулсан, 2021 оны 10 дугаар сарын 01-нд дуусахаар гэрээтэй боловч гэрээгээ сунгаагүй.	250.0	Зөвлөмж өгсөн	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж өгсөн
	B.2.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх захиалагч, зохиогч, маргэжлийн байгууллагын хяналт үр дүнтэй хэрэгжсэн үү?	Аудитын үеэр зохиогчийн хяналт нь, барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл, хяналтын тайлангаар нотлогдоогүй, интернэтээр хянасан мөртлөө илүү нэхэмжилсэн	16.9	Төлбөрийн акт	Хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт
	B.3.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, үр шалтны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулж, үр дүнг тооцсон үү?	Захиалагчийн хяналтын зардлыг Аймгийн ЗДТГ, ГХБХБ-ын автомашинуудын засварт зориулалт бусаар зарцуулсан	20.0	Зөвлөмж өгсөн	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж өгсөн
	B.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон үү?	Идэр сумын сургууль, Шилүүстэй сумдын ЗДТГ, Балжархайрхан сумын цацарлэгийн барилгуудын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон	528.2	Зөвлөмж өгсөн	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж өгсөн
Дүн			1,399.3	Зөвлөмж өгсөн	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж өгсөн
			2,612.9			

Алдаа зөрчлийн бүртгэлийн маяг хөтөлсөн:

Хянасан: Ахлах аудитор *P.Bole* г.Заяа



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 1301/191.

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд” хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга /Д.Түвшинжаргал/-д хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлэхийг Аймгийн засаг даргад зөвлөсүгэй.

4. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын хоёрдугаар алба /ахлах аудитор Г.Заяа/-д даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын хоёрдугаар алба /ахлах аудитор Г.Заяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Audit(D)tushaal2022

0130121/8